



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/531

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 102 дугаар сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 7,462,918.98 (долоон сая дөрвөн зуун жаран хоёр мянга есөн зуун арван найман төгрөг ерэн найман мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтын дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын 53 дугаар сургууль, 21 дүгээр сургуулийн балансад тус, тус шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 102 дугаар сургууль (Г.Гүнбаяр)-д зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 53 дугаар сургууль (Л.Амарсанаа), 21 дүгээр сургууль (Г.Оюунчимэг)-д тус, тус үүрэг болгосугай.


3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс /Г.Тэмүүжин/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

В.Оюумаа

В.ОЮУМАА

1150501028



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн ерөнхий боловсролын 102 дугаар сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашигла лтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуриутлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Сурагч ширээ		2007	ш	37	8,666.67	320,666.79	307,305.68	13,361.11	53-р сургууль
2	Сурагч сандал		2007	ш	73	4,666.67	340,666.91	326,472.00	14,194.91	
3	Ширээ сандал /6 настай хүүхдийн/		2009	ком	28	17,913.76	501,585.28	320,457.20	181,128.08	
Тавилга, эд хогшлын дүн										
4	1-р хоолны тогоо	250 л	2024	ш	1	6,300,000.00	1,162,918.98		1,162,918.98	21-р сургууль
	Дүн						6,300,000.00	-	6,300,000.00	
	Шилжүүлэх нийт хөрөнгийн дүн						7,462,918.98			